

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ч.ЭРДЭНЭБААТАР МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДТАЙ БАЙГУУЛСАН
БАТЛАМЖ ГЭРЭЭНИЙ 2010 ОНЫ БИЕЛЭЛТ**

2011-02-08

№	Батламж гэрээний агуулга	Биелэлт	хувь
1.	Аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	Аймгийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахдаа аймгийнхаа иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг хангахын тулд юуны өмнө өөрийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулах явцад иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, сумдаас 500 гаруй бүтээлч санал ирүүлснийг нэгтгэн боловсруулж, аймгийн ИТХ, Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн эдгээр саналын 80 шахам хувийг мөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн засаг даргын мөрийн хөтөлбөр нь Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцтай салшгүй холбоотой бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний 2009 оны хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд Хэнтий аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 91 зорилтын 158 арга хэмжээний хэрэгжилт 2008-2012 онд харьцуулсан байдлаар 37,5%-ийн хэрэгжилттэй байгаа ба 2009 оны хувьд 100%-ийн биелэлттэй байна.	100%
2.	Төр засгийн төлөөлөгчийн хувьд төрийн хууль ёсыг чандлан сахиж, Монгол улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.	<p>Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд 2009 онд 326 захирамж гаргаж ажиллалаа. Сумдын Засаг даргын 1011 захирамжийг хянаж, эрх зүйн зөрчилтэй 186 захирамжийн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, Хэрлэн сумын засаг даргын 1, Бэрх хотын захирагчийн 1 захирамжийг хүчингүй болгуулан зөрчлийг арилгуулав. Захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хангах талаар холбогдох албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласны үр дүнд зөрчилтэй актын тоо 2008 оныхтой харьцуулахад 210-аас 186 болж буурлаа. Энэ онд эрх зүйн мэдээллийн цахим сан legalinfo болон гар сангаас иргэд байгууллагуудад 216 лавлагаа олгож, 352 хүнд хууль зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>Монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газар, МХГ-тай хамтран компьютер тоглоомын газруудыг шалгаж, “Ажиллах хүч гадаадад гаргах, ажиллах хүч гадаадаас авах тухай” хуулийн хэрэгжилтийг аймгийн МХГ, Тагнуулын хэлтсийн ажилтнуудтай хамтран Галшар сум, Бор-Өндөр хотын нутаг дэвсгэрт уул уурхай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудад шалгав. Цагдаагийн газартай хамтран орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа банк, шатахуун түгээх станц зэрэг 64 аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, сонор сэрэмжийг шалган зааварчилж, аж ахуйн нэгжүүдэд хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга тараав.</p> <p>Мөн МХГ, БОАЖГ газартай хамтран уул уурхайн ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад Монгол улсын “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, Газрын тухай”, “Усны тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай”, “Эрүүл ахуйн тухай” хуулийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох ажлыг хийлээ.</p>	100%
3.	Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид байлган, иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар шуурхай үйлчилнэ.	Төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод, иргэд байгууллагад хүртээмжтэй болгох зорилгоор Монгол улсын Засгийн газраас баталсан “Нэг цонхны үйлчилгээ” байгуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд 2009 оны 4 сарын 27-нд “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийг нээж, төрөөс үзүүлж буй төрөл бүрийн үйлчилгээг нэг газраас олон төрлийн хэлбэрээр буюу “нэг цонх”-ноос үзүүлж байна. Уг төв иргэдэд нийгмийн даатгал, хөдөлмөр халамж, иргэний бүртгэл, мэдээлэл, газрын харилцаа, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, зөвлөмж, мэдээлэл өгөх, банк, нотариат гэх мэт олон чиглэлээр нэг дор үйлчилгээ үзүүлж байгаа нь иргэдийн талархлыг хүлээсэн арга хэмжээ боллоо. Нэг цонхны үйлчилгээнд 2009 онд нийтдээ 24921 иргэн хамрагдаж төрийн үйлчилгээг нэг дороос авсан байна. Үйлчлүүлэгчдээс авсан санал асуулгаар 88% нь нэг цонхны	100%

үйлчилгээний төвөөс хүссэн үйлчилгээгээ авч чадсан байна.

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газарт бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр иргэдийн өргөдөл гомдол хүсэлт, дотоод ажил, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэнг томилон, иргэдийг хүлээн авах өрөөнд бүх төрлийн сонин хэвлэл, гарын авлага ном, Монгол улсын хуулиудын боть, бусад шаардлагатай гарын авлага материал, мэдээллээр иргэдэд үйлчлэх нөхцөл боломжийг хангаж, иргэдээс санал хүсэлт гомдол хүлээн авах 23303 дугаартай утас ажиллуулж байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, биелэлтийн явцыг иргэдэд сурталчлах зорилгоор Хэнтий аймгийн вэб хуудсыг шинэчилж, электрон шуудангаар харилцах, уулзалт цуглаан зохион байгуулах, орон нутгийн телевиз, FM радиогоор иргэдтэй шууд харилцах, саналын хайрцаг, санал асуулга явуулах зэрэг хэлбэрээр иргэдэд мэдээлэл хүргэж, мөн эдгээр сувгаар иргэдийн санал хүсэлт, захидал, өргөдөл гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч ажиллаж байна.

Засаг дарга бүх сумаар 1-3 удаа явж ажил байдалтай газар дээр нь танилцаж асуудлыг шийдвэрлэж ажилласан ба оны эцэст өөрийн хийсэн ажлын тайлан болон тухайн сумын Засаг дарга нарын тайланг иргэдэд танилцуулж, нийтдээ 2000 гаруй иргэдийг хамруулан зохион байгууллаа. Аймаг орон нутагт тулгамдсан асуудлаар Засаг даргын зөвлөл 18 удаа хуралдаж, 34 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, хуралдааны бүх үйл ажиллагааг аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр иргэдэд дамжуулж, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллав.

2009 онд Засаг дарга агентлагийн дарга нартай 3 удаа, сумдын Засаг дарга нартай 3 удаа, аймгийн бүх 83 багийн Засаг дарга нартай 1 удаа ажил хэргийн уулзалт зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр уг уулзалтуудын үйл ажиллагаа, шийдвэрийг иргэдэд мэдээллээ.

Иргэдийн санал хүсэлт хүлээн авах шууд утсаар 29 иргэний 32 гомдол хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн ба иргэдээс аймгийн Засаг даргад хандан уулзалт хурал дээр болон бичгээр ирүүлсэн нийт 475 өргөдөл гомдол хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 2009 онд аймгийн Засаг дарга захирамжаар 46 хүнд 2 сая 130 мянган төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүллээ.

Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албаны хүнд суртал, иргэдийг чирэгдүүлдэг, хариуцлагагүй, ёс зүйгүй байдлыг арилгах зорилгоор аймгийн Засаг даргын санал болгосноор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Төрийн байгууллагын шударга ёс, ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, байгууллага иргэдийн санал авах ажлыг нээлттэй зохион байгуулан, мөн Авлигатай тэмцэх газрын санал зөвлөгөөг тусгаж “Төрийн байгууллагын шударга ёс, ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г аймгуудаас анх удаа батлан гаргаж мөрдөн ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд суртал, чирэгдлийг таслан зогсоох, төрийн захиргааны байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах чиглэлээр нийт 4 тулгуур, 6 зорилт бүхий 20 заалт тусгаж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн 35% буюу 8.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулахаар шийдвэрлэлээ.

Уг төлөвлөгөөний дагуу төрийн байгууллагуудад мөрдөж байгаа дүрэм журам, ажлын байрны тодорхойлолт зэрэг баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, байгууллагууд нээлттэй утас ажиллуулж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авдаг боллоо. Ёс зүйтэй манлайллыг аймгийн төрийн байгууллагын удирдлагууд өөрсдөөсөө эхэлж, шударга ёс хуулийг дээдлэн ажиллах, гаргаж буй шийдвэр, явуулж байгаа үйл ажиллагаагаа олон түмэнд ил тод нээлттэй байлгах, нийтийн эрх ашгийн хүрээнд гаргаж буй шийдвэрийг боловсруулахдаа иргэд, олон нийтийг оролцуулж саналыг нь авч байх уриалга гарган ажиллаж байна. Төрд алба хааж буй хэн боловч шударга ёсыг дээдлэн үйл ажиллагаагаа нээлттэй ил тод байлган, иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй үйлчлэх талаар төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, байгууллагын дотоод журам, дүрмэнд тусгаж, аймгийн ЗДТГ аливаа тендер, сонгон шалгаруулалт, худалдан авах ажиллагааг нээлттэй ил тод явуулах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудаар хяналт тавиулж, үндэслэлгүй төлбөр хураамж авах асуудлыг эцэс болгох ажлыг эхлүүлээ. Эдгээр ажлыг хэрэгжүүлэх явц үр дүнд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний оролцоотой хяналт шалгалт мониторинг хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна.

4.	<p>Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авлига хээл хахуулийг цээрлэн ажиллана.</p>	<p>Хэнтий аймаг 2009 онд орон нутгийн төсөвт 4390,4 сая төгрөг төвлөрүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг 441,6 сая төгрөгөөр буюу 11,2 хувиар давуулан биелүүлж, орон нутгийн төсөвт байгууллагуудад 3746,1 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийж, орон нутгийн зарлагаас давсан 470,8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээр тус аймаг төсвийн хувьд бие даан ажилласан анхны жил боллоо. Төсвийн сахилгыг чанд сахин ажилласнаар 2009 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардлыг 102,7 сая төгрөгөөр хэмнэсэн дүн гарлаа. Төрийн сангийн төлбөр тооцооны журам зөрчиж төсвийн зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналтыг муу хийсэн Баянмөнх сумын төрийн сангийн төлөөлөгч, Хэрлэн, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Баянмөнх сумдын зарим төсөвт газруудын нягтлан бодогч нарыг ажлаас нь чөлөөлөн хариуцлага тооцож бусад сум байгууллагуудад мэдэгдэн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар анхааруулан ажиллаж байна. Санхүүгийн жилийн эцсийн нэгдсэн тайлангаар орон нутгийн төсөв өглөггүй гарч, авлагыг өнгөрсөн оны мөн үеэс 27,6 хувиар бууруулсан байна.</p> <p>Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан авилгатай холбоотой болон хээл хахуулийн хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлан, түүнийг арилгах арга хэмжээ авах зорилгоор Цагдаагийн газарт үүрэг өгч ажиллаж байна. Аймгийн цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2 албан тушаалтанд холбогдох хэргийг харьяаллын дагуу АТГ-г шилжүүлсэн байна. Хэрлэн сумын иргэн Оюунцэцэг, Цэцэгээ нараас аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн ажилтнуудын хүнд суртал, бусдаас шан харамж авдаг талаар ирүүлсэн гомдлыг шалгаж ХХҮХ-ийн даргад 2009 оны 8 сарын 18-ны өдрийн 4/905 тоот албан бичгээр үүрэг өгч ажиллалаа.</p> <p>Авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг ажлын байрны тодорхойлолтод нь тусган аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн даргад хариуцуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргавал зохих 415 албан хаагчийн ХОМ-ийг хугацаанд нь бүрэн гаргуулан авч тайланг АТГ-т хүргүүлэв. Авилгын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар орон нутгийн FM радиогоор 4 удаа, орон нутгийн телевизээр 2 удаа, ТВ-9 телевизээр 2 удаа, Өнөөдөр сонинд 1 удаа, “МОНЦАМЭ мэдээлэл” сонинд 2 удаа, орон нутгийн МЭДЭЭЛЭЛ сэтгүүлд 2 удаа мэдээлж сурталчлан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд 2 удаа мэдээлэл хийж сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.</p>	100%
5.	<p>Аймгийн эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж ажиллана.</p>	<p>Аймгийн эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж ажиллах зорилтын хүрээнд:</p> <p>Соёлын салбар: Мэргэжлийн урлагийн байгууллага Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулга нь хөдөөгийн ард иргэдэд 37 удаа, бичил тоглолт 16 удаа тус тус зохион байгуулж нийт 32000 гаруй хүн амд соёл урлагийн үйлчилгээг хүргэж, шинээр 4 уран бүтээл туурвиж “Учиртай 4 толгой” жааз мюзиклыг 2011 оны 2 сард тоглоход бэлэн болоод байна. Уран бүтээлчдийн найруулж дэглэсэн, зохион туурвисан бүтээлүүдийг гэрээний дагуу өөрсдийн урын сандаа худалдан авч тоглолт болон концертын хөтөлбөрт оруулахын зэрэгцээ аймгийн Боловсрол соёлын газартай хамтран сумдын соёлын төвийн дуу хөгжим, бүжгийн багш нарын мэргэжил дээшлүүлэх нэгдсэн сургалтыг 2 удаа зохион байгуулж 45 багш нар хамрагдлаа. Мөн Урлагийн гавьяат зүтгэлтэн Д.Санжаасүрэнгийн нэрэмжит зүүн бүсийн театр чуулгуудын мэргэжлийн бүжигчид, ЕБС-ын сурагчдын дунд зохион байгуулсан уралдаанд 7 аймгийн 30 гаруй бүжигчид, 150 гаруй сурагчид оролцож, улсын хэмжээнд зохион байгуулсан Монгол үндэстний дууны их наадам, ардын богино дууны улсын уралдаанд 15 уран бүтээлчид оролцож нэрэмжит шагналуудыг хүртлээ.</p> <p>Нийтийн номын сан: Улсын төсвийн хөрөнгөөр 270 нэр төрлийн 4,1 сая төгрөгийн 430 ш номоор, хандиваар 179 нэр төрлийн 1,7 сая төгрөгийн 200 ш ном нийт 630 номоор фонд баяжилт хийснээр фонд баяжилт 2,8%-иар нэмэгдсэн байна.</p> <p>Музей: Аймгийн музей нь 4000 иргэнд үйлчилэхээс 6000 орчим иргэнд үйлчилж, 1,5 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 100% биелүүллээ. Үзмэр авах зардлаас 27 дэсийн 49 үзмэрийг худалдан авч гэрэл зурагжуулж ерөнхий бүртгэлд бүртгээд байна. Мөн Өвгөн ноён М.Пүрэвжавын нүүдлийн музейг шинээр дэглэн 300 гаруй иргэд үзэж сонирхон аймгийн Засаг даргын нөөцөөс 1,0 сая төг зарцууллаа.</p> <p>Соёлын төв: 17 сумын соёлын төвийн байгууллагын тохижилт, техник хэрэгсэл, эд хогшил зэрэг материаллаг бааз дээшлүүлэх, ТА-2 төсөл, хөтөлбөр, хандив, хөрөнгө оруулалтаар нийт 106.6 сая төгрөгийн</p>	100%

		<p>хөрөнгө оруулалт хийгдсэн байна. УБ хотын Соёлын дээд сургуулийн эчнээ сургалтанд соёлын төвийн эрхлэгч 4, хөгжмийн багш 4, бүжгийн багш 8, номын санч 4, музей 2, нийт 26 соёлын ажилтнууд хамрагдан суралцаж байгаагаас 13 соёлын ажилтан диплом, бакалаврын ангийг төгсөж мэргэжлийн боловсон хүчний хангалт 68 % -д хүрч өмнөх оноос 12%-иар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Боловсрол: 2009-2010 оны хичээлийн жилд суурь боловсролын хамран сургалт 90%-тай, СӨБ-ын хамран сургалт 89,2%-д хүрч, өмнөх оноос 10,7 хувиар, бага боловсролын хамран сургалт 97,5%-д хүрч өмнөх оноос 0,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. ЕБС-д 14785 хүүхэд хамрагдсанаас сурлагын амжилт 98.8, чанарын дундаж үзүүлэлт 54.9 хувьтай буюу өмнөх оны үнэлгээнээс амжилт 4,3%-иар, чанар 2,5 хувиар өссөн байна. СӨБ-ын стандартын хэрэгжилтэд түвшин тогтоох үнэлгээ хийж, хөндлөнгийн болон цэцэрлэгийн өөрсдийн үнэлгээг харьцуулахад СӨБ-ын стандартын хэрэгжилт хангалттай сайн түвшинд хэрэгжиж байна. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх нь багшийн хөгжлийн цаашилбал аймгийн боловсролын хөгжлийн тулгуур гэж үзэн хөрөнгө санхүүгийн бололцоогоо дайчлан БСШУЯ, МУБИС, улсын олсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж 9 сая гаруй төгрөг зарцуулж, улсын хэмжээний сургалтанд 125, бүсийн сургалтанд 278, аймаг, орон нутгийн сургалтанд 376 багшийг хамрууллаа. Аймгийн төвийн 4 сургууль, сумдын 9 сургууль багшийг ажлын байрандаа хөгжих бололцоогоор хангаж, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр ханган ажиллаж, 6 сургуульд 248 сая төгрөгийн өртөг бүхий “Багшийн хөгжлийн төв” байгуулсан. Боловсролын хөгжлийн хөтөлбөр, Азийн хөгжлийн банкнаас сумдын 3 сургуульд иж бүрэн электрон номын сан олгосон нь сурагч багш нарын сурч ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлж өглөө. Аймгийн төвийн 4 сургууль, сумдын 4 сургууль интернэтэд холбогдон цахим мэдээллийг ашиглан, мэдээлэл авах, харилцан туршлага солилцоход чухал алхам боллоо. Улсын төсөв, төсөл хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн мэдээлэл зүйн кабинетийн компьютерийн хангалт 2008 онд 310 буюу нэг компьютерт ногдох хүүхдийн тоо 20, 2009 онд 426 буюу 1 компьютерт ногдох хүүхдийн тоо 16, 2010 онд 478 болж 1 компьютерт ногдох хүүхдийн тоо 14 болсон ахиц гарлаа. 2010 онд СӨБ-ын багшийн хангалт 68,8% байгаа нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 14 хувиар ахиж, ЕБСургуулийн багшийн хангалт 100%-д хүрлээ. Аймгийн Засаг даргын санаачлагаар багшийн ажлыг бодитой үнэлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор жил бүр аймгийн "Тэргүүний багш"-д сургуулиас 3 багш, СӨБ-аас 1 багшийг шагнаж урамшуулахаар шийдвэрлэж, нийт 15 багшийн материал ирснийг журмын дагуу шалгаруулж 1.8 сая төгрөг зарцууллаа. Боловсролын салбарт 2010 онд 4,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь өмнөх оноос 0,6 тэрбум төгрөгөөр өсч сургууль, цэцэрлэг, дотуур байрны 3 барилга шинээр барьж, 5 барилгад их засвар хийж багш сурагчдын сурч, ажиллах таатай нөхцлийг бүрдүүллээ. Орон нутагт шаардлагатай мэргэжлээр чадварлаг боловсон хүчин бэлтгэх, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс хариуцан гэрээгээр суралцуулах журам” боловсруулан баталж, 2008-2009 оны хичээлийн жилд 4 оюутны сургалтын төлбөрт нийт 2,7 сая төгрөг, 2009-2010 оны хичээлийн жилд 7 хүүхдийн сургалтын төлбөрт 4,7 сая төгрөг зарцуулав. Гадаад харилцаагаа өргөжүүлэн, орон нутгийн оюутан залууст чанартай боловсрол эзэмшүүлэх зорилгоор 2008 оноос эхлэн ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар мужид 5 оюутан сургаж байна.</p> <p>Эрүүл мэндийн салбарт: 2010 онд нийт 3,2 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс УАУТөвийн барилга 494.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр “БЧХ” ХХК шалгарч ажлыг хугацаанд нь эхлүүлэн одоогоор подваль суурийн ажил дуусч 1 давхрын өрлөг хийгдэж ажлын явц 40 %-тай, Халдвартын 30 ортой эмнэлэгийн барилга нийт өртөг 719,3 сая төгрөг өртөгтэйгээр гүйцэтгэгчээр “ААББ” ХХКомпани шалгарч барилга угсралтын ажлын явц 55.6 %-тай байна.</p> <p>Өмнөдэлгэр сумын 10 ортой эмнэлгийн барилга 330.2 сая төгрөгийн өртөгтэйгээр “Суварга эв” ХХК, УАУТөвийн “Саамны сувилал”-ын гадна шугам сүлжээний засварын ажлын гүйцэтгэгчээр “Бодит-Орд” ХХКомпани, Жаргалтхаан сумын эмнэлгийн их засвар 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажлын гүйцэтгэгчээр “Баялаг хурх” ХХК шалгарч барилгын засварын ажлыг гүйцэтгэж улсын комисст сайн үнэлгээтэй хүлээлгэн өгч хөдөөгийн эмнэлгийн ажиллах нөхцөл боломжийг сайжруулан үйлчлүүлэгчдэд ээлтэй тав тухтай орчин бүрдүүллээ.</p> <p>ЭМЯамны хөрөнгө оруулалтаар аймгийн нэгдсэн эмнэлэг, ЭМГазар, Бор-Өндөр, Дадал, Өмнөдэлгэр, Батширээт сумын эмнэлэгт түргэн тусламжийн автомашин, БГХӨСТөв фургон автомашинаар хангагдав. Мөн Галшар, Дархан, Өлзийт, Батноров, Бор-Өндөр сумдын эмнэлэгт шаардлагатай байгаа автомашины саналыг ЭМЯаманд уламжлан 2011 оны хөрөнгө оруулалтын судалгаанд тусгуулсан. "Уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэх нь" төсөл Өмнөдэлгэр, Мөрөн сумын эмнэлэгт 2006 оноос хэрэгжсэн ба 2010 онд Баянмөнх, Дархан, Хэрлэн суманд хэрэгжүүлж эхлээд байна. Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 4 багт шинээр эмч ажиллуулж, “Тогтвортой амьжиргаа-2” төслөөр Цэнхэрмандал, Баян-Адрага сумын 2 багийн эмчид</p>
--	--	---

	<p>мотоцикль, 2 багийн эмнэлгийг тохижууллаа.</p> <p>Хүний нөөцийн 2009-2019 он хүртлэх стратеги төлөвлөгөө боловсруулан эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхэд анхаарч төрийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт эмгэг судлаач эмч, нярайн эмч, Батноров, Баян-Адрага суманд хүүхдийн эмч, Бор-Өндөр, Жаргалтхаан суманд гэмтлийн эмч бэлтгэхээр мэргэжил олгох сургалтанд хамруулав. Мэргэжил дээшлүүлэх сургалтанд сэхээн амьдруулах, дотор, мэс засал, мэдрэл, эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр 6 эмч, тусгай дунд мэргэжилтнүүдээс мэргэжил дээшлүүлэх сургалтанд нярай, эх баригч, лаборант мэргэжлээр, олгох сургалтанд нярай, сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ, мэс заслын мэргэжлээр, бакалаврын сургалтанд 14, төв, бүсийн сургалтанд 38, орон нутагт зохион байгуулсан сургалтанд 278, зайны сургалтанд 19 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна.</p> <p>Биндэр сум дундын эмнэлэгт шүдний эмч, мэс заслын эмчийг томилон ажиллуулж ЭХО-ийн баримжаа олгох сургалтанд 3 их эмч, Өмнөдэлгэр сумын эмэгтэйчүүдийн эмчийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд, Хэрлэн дом өрхийн эмнэлгийн ахлагчийг өрхийн эмчийн олгох сургалтанд тус тус хамруулсан. 2010 онд өрхийн эмнэлгүүдэд 4 их эмчийг шинээр томилон ажиллуулсанаар өрх, сумдын эмнэлгийн их эмчийн хангалт 100 хувь, Нэгдсэн эмнэлгийн их эмчийн хангалт 95 хувьтай байна.</p> <p>Батширээт, Галшар, Баян-Овоо сумдад 2 их эмч, Биндэр суманд сэхээн амьдруулах мэдээгүйжүүлэлтийн эмчийг томилж төрийн санхүүжилтээр сургалтанд хамрууллаа. Бэрх сум дундын эмнэлгийн мэс заслын эмчийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд, Өмнөдэлгэр, Бор-Өндөр сумдаас хүүхдийн эмчийн мэргэжил олгох сургалтанд хамруулж байна. Сумдад ажиллаж буй эмч нар эмчийн орон сууцаар 100% хангагдлаа.</p> <p>2010 онд аймгийн Засаг даргын захирамжаар 2.4 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэж сумдыг 3 бүс болгон “Явуулын амбулатори” ажиллуулан хөдөөгийн малчин айл өрхийн 14000 гаруй иргэдэд мэс засал, эмэгтэйчүүд, дотор, сүрьеэ, арьс бэлгийн зам, лабораторийн оношилгоо гэсэн мэргэжлийн чиглэлүүдээр урьдчилан сэргийлэх үзлэг хийж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулж гарын авлага материалаар хангалаа.</p> <p>2010 онд аймгийн хэмжээнд 1388 эх төрсөн нь 2009 оны мөн үеийнхтэй харьцуулахад 11,0 хувь буюу 172 төрөлтөөр буурч, жирэмсний хяналтанд 1766 эхийг хяналтанд авснаас 76,5 хувь нь эхний 3 сартай хяналтанд орсон байна. Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19,5 (27) промил байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9,7 промилоор буурсан /улсын дундаж 19.4 промил/, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 28,1(39) өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 31.7(50) байгаа нь урьд оныхоос 3,6 промилоор буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Бүх халдварт өвчнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гепатит /393/ 182 тохиолдлоор, сүрьеэ /176/ 59 тохиолдлоор, бруцеллез /67/ 36 тохиолдлоор, хамуу /26/ 26 тохиолдлоор, цусан суулга /71/ 27 тохиолдлоор өссөн ба БЗДХ /316/ 157 тохиолдлоор, салхин цэцэг /5/ 47 тохиолдлоор, гахайн хавдар /14/ 10 тохиолдлоор тус тус буурсан байна. 12 сарын байдлаар гар хөл амны өвчин нийт 129 тохиолдол, ёлом 1, хачигт рекиттиоз 1, боом 2 тохиолдол бүртгэгдээд байгаа ба сүрьеэ 6, цусан суулгаар 1 тохиолдлоор нас барсан байна.</p> <p>“Бүх халдварт өвчнүүд дотор БЗДХ 26,0(316), гепатит 32,3 (393), сүрьеэ 14,5 (176), гар хөл амны өвчин 10,6(129), цусан суулга 5,85 (71), бруцеллез 5,51 (67), хамуу 2,14 /26/ хувийг тус тус эзэлж байна.</p> <p>Эрүүл мэндийн салбар 2010 оны 11 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр 55,7 сая төгрөгийн өр үүссэнийг Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлгийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан 21,6 сая төгрөгийн өрийг шийдвэрлүүлсэн бөгөөд ЭМЯамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын 5/4594 албан бичгээр зардал хооронд нь 34107,3 мян төгрөгийг шилжүүлж өрийг барагдуулснаар 2010 онд ЭМСалбарын хэмжээгээр өргүй ажиллалаа.</p> <p>Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс 2009 онд явуулсан хүн амын ядуурлын түвшинг тогтоох судалгаанд аймгийн хэмжээнд 19511 өрх хамрагдсанаас 7261 өрх буюу нийт өрхийн 37,2 хувь нь “ядуу” гэсэн судалгаа гарсан.2010 оны хувьд ядуу болон нэн ядуу иргэдийн судалгааг гаргаж мэдээллийн сантай болж аймгийн хэмжээнд 6778 өрх ядуу байгаагаас 3542 өрх нэн ядуу буюу 34,6 хувь болж багассан байна. Нэн ядуу өрхийг сум орон нутгийн амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэж тогтоосон. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээр дамжуулан бүртгэлтэй байгаа 944 хүнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж 80,7 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж эдгээр иргэдийн 672 нь эмзэг бүлгийн иргэд хамрагдсан. 2010 онд нийт 353 өрхийг ядуурлаас гаргахад бодит дэмжлэг үзүүлээ. 2010 онд ногоочин, гар урлал-бэлэг дурсгал, оёдол, цахилгаан гагнуур, гоо сайхан, цэцэрлэгийн туслах багш, хүнд машин механизмын операторчин, тогооч, барилгын засал чимэглэл, барилгын мужаан зэрэг сургалтуудыг МСҮТ, Абука, Арука, Мастер, Шинэ хөгжлийн гарц зэрэг сургалтын төвүүдтэй хамтран зохион байгуулж 295 иргэн хамрагдаж 33,6 сая төгрөгийн санхүүжилт</p>	
--	--	--

		<p>хийгдээд байна.Мөн 2010 оны 4-р сард Аймгийн ХХҮХ, МСҮТ-тэй хамтран хорих ангид ял эдэлж буй 25 иргэнийг барилгын засал чимэглэлийн мэргэжил олгох 14 хоногийн сургалтанд хамруулж сертификат олгосон. Сургалтанд хамрагдсан иргэдийн 73% буюу 215 иргэн түр болон байнгын ажлын байраар хангагдаад байна. Нийтийг хамарсан ажил, ажил олгогчийн урамшуулал, мэргэжлийн сургалт, зөвөлгөө өгөх, үйлчилгээнд давхардсан тоогоор 1089 хүнд 260,4 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулаад байна. Малгүй болсон буюу малаа их хэмжээгээр хорогдуулсан 20 малчин өрхөд ХЯБХөтөлбөрөөс 80 ,0 сая төгрөгийн 3206 толгой бог мал олгосон. Түүнчлэн сум бүрт жижиг бизнесийг дэмжих зорилгоор тус бүр 20.0 сая төгрөг, Хэрлэн суманд 160.0 сая төгрөгийн зээл олгосон.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаагүй эмзэг бүлгийн Хэрлэн сумын 400 иргэнд 400 м.куб түлээний мод бэлтгэн олгож, эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүхий өрхүүдийн ерөнхий боловсролын сургуульд суралцдаг 250 хүүхдэд сурагчийн дүрэмт хувцас олгосон.</p> <p>Өндөрхаан хотод баригдаж шинээр ашиглалтанд өгсөн 48 айлын орон сууцанд орсон 24 төрийн албан хаагчийг ХААН банкны орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулсан. Амьдралын гачигдал бэрхшээлийн улмаас мөнгөн тусламж, эмчилгээний зардал, оюутны сургалтын төлбөр зэрэг тусламж хүссэн 258 иргэнтэй биечлэн уулзаж 9,480 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж, эмзэг бүлгийн өрхийн 7 оюутны сургалтын төлбөрийг аймаг бүрэн хариуцан сургаж байна.</p> <p>"Ногоон ажлын байр"хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 60-аас доошгүй хувь нь буюу 72 нь эмзэг бүлгийн иргэдийг хамруулсан.Нийт 120 иргэнийг хамруулж 9000,0 мянган төгрөг зарцуулж сум бүхэнд бүрэн хэрэгжсэн.</p> <p>2010 онд нийгмийн халамжийн тухай хуулинд заагдсаны дагуу 18-24 насны бүтэн өнчин өссөн, гэнэтийн аюул ослоос гэр оронгүй болсон 39 хүнд гэртэй болоход нь дэмжлэг үзүүлсэн.Засаг даргын захирамжаар хүчтэй салхинд гэргүй болсон 6 өрхө тус бүр 200,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. ХХҮХ-ээс тэнэмэл амьдралтай иргэдэд туслах зорилгоор 18 иргэнийг түр орогнуулах байранд байршуулаад 750,0 мян төгрөг зарцуулаад байна. Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэснээр нийгмийн салбарын хүрээнд тодорхой ахиц гарч 2009 онд ажилгүйдлийн түвшин 3.3%-тай байсан бол 2010 онд 3.2% хувьтай болсон байна.</p>	
6.	Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, гэмт хэрэг, архиан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга хариуцлагыг өндөржүүлж ажиллана.	<p>"Хан Хэнтий хөгжлийн өдөр буюу 3 дугаар сарын 3-ны өдөр"-ийг угтаж архиан согтуурах явдлыг бууруулах, хууль сурталчлах зорилгоор "Архидалтын эсрэг бид хамтдаа" сарын аяныг аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, аймгийн ЗДТГ, "Дэлхийн зөн" Олон улсын байгууллага, Нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн газар хамтран явуулж, архины хор уршиг, түүнээс үүдэн гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, анхаарах асуудлын талаар нэгдсэн эмнэлэг, Дэлхийн зөн байгууллагатай хамтран "Санбүрд" телевиз, FM радиогаар санамж, сэрэмжлүүлэг, мэдээлэл явуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас "Хан Хэнтийн хөгжлийн өдөр"- 3 сарын 3 болон сар бүрийн 25-нд архи, согтууруулах ундаа худалдан борлуулахгүй өдөр болгон ард иргэдэд уриалга гарган мөрдөж ажиллаж байна.</p> <p>Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газраас Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Хуулиа хэн сайн мэдэх вэ" АХА тэмцээн явуулж, 5 сургуулийн сурагчид оролцов.</p> <p>Хэрлэн сумын архины хамааралтай нэр бүхий 10 иргэнд сайн дурын архины эмчилгээг ЭМГ-тай хамтран хийж шаардагдах санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олголоо.</p> <p>Мөн аймгийн засаг дарга орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Цагдаагийн газарт 10.0 сая төгрөгийн өртөг бүхий хөдөлгөөнт эргүүлийн 2 автомашин авч өгснөөр нийгмийн хэв журам сахиулах ажилд ахиц гарч байна.</p> <p>Монгол улсын "Архиан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн заалтыг зөрчсөн, ажлын байранд архиан согтуурсан, зөвшөөрөлгүй болон хүүхдэд архи согтууруулах ундаа зарсан, гар дээрээс согтууруулах ундаа зарсан, хориглосон өдөр архи худалдаалсан зэрэг зөрчил гаргасан 16 аж ахуйн нэгж, 6 албан тушаалтан, 73 иргэн, нийт 95 зөрчилд 4,7 сая төгрөгний торгуулийн арга хэмжээ авав.</p> <p>Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль", холбогдох хууль эрх зүйн актуудын биелэлтийг 631 аж ахуйн нэгж байгууллагын харуул, хамгаалалтын ажилтнуудын сонор сэрэмж, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг шалган илэрсэн зөрчил дутагдлыг засуулах албан мэдэгдэл хүргүүлж,урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Бодь суварга ХХК-тай хамтран харуул хамгаалалтын ажилтнуудын сургалтыг Өндөрхаан хотын хэмжээнд зохион байгуулж, 74 албан хаагч, иргэдэд мэргэшлийн сертификат олголоо. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ явуулдаг нийт 266 цэгт хяналт тавих үүднээс Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжил зүйн төв, Татварын хэлтэс, Цагдаагийн газар болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран давхардсан тоогоор 178 удаа 606 цэгт шалгалт хийж, үйл ажиллагаа явуулахгүй байгаа 14 аж ахуйн</p>	100%

		<p>нэгжийн 4 баар, 14 хүнсний дэлгүүрийн үйл ажиллагааг хүчингүй болгон, 18 цэгт үйл ажиллагаа явуулах эрх шинээр олгов.</p> <p>Хэрлэн сумын хэмжээнд нийгмийн хэв журам сахиулах олон нийтийн 12 байцаагч томилон ажиллуулж сумын ИТХ-тай хамтран тэдний дунд сургалт зохион байгуулж, цагдаагийн алба хаагчийн хамт эргүүлд гарган сарын ажлын үр дүнг тооцон сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс урамшуулал олгож байна.</p> <p>Аймгийн нутаг дэвсгэрт гарч буй гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүгнэлт хийж эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг эрүүлжүүлэх, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн газар тасаг, албадаас 49 удаа нэгдсэн арга хэмжээ, 157 хэсэгчилсэн арга хэмжээг цагдаагийн газрын тасаг албад, алба хаагчдын хүчээр 7-30 хоногийн хугацаагаар зохион явуулав. Эдгээр ажлын үр дүнд гэмт хэргийн гаралт аймгийн хэмжээнд 2008 онтой харьцуулахад 17,5%, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 20,8%, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 3,5%-иар буурсан байна.</p>	
7.	Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, удирдах бусад албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг туслалцаа авч ажиллана.	<p>2010 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн Зарлиг 1, Засгийн газрын тогтоол 40, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 7, Ерөнхий сайдын захирамж 1-ийг шинээр бүртгэн, Ерөнхийлөгчийн Зарлигийн 1 заалт, Засгийн газрын тогтоолын 53 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 7 заалтыг тус тус нэмж хяналтанд авсан байна. Биелэлтийг тооцохдоо 2005-2009 онуудад гарсан зарим шийдвэрүүдийн заалтууд нь бүрэн хэрэгжсэн буюу хэвшсэн гэж үзээд Засгийн газрын 33 тогтоолын 61 заалт, 9 хуралдааны тэмдэглэлийн 12 заалт, Ерөнхий сайдын 6 захирамжийн 7 заалт, 1 албан даалгаварын 5 заалтыг хяналтаас хассаныг шийдвэрүүдийн нэр, заалтаар гаргаж хавсарган ЗГХЭГ-ын ХШҮ-ний хэлтэст хүргүүлсэн. 2010 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын Ерөнхийлөгчийн Зарлиг, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар зэрэг хяналтанд байгаа нийт 147 шийдвэрийн 236 заалтын биелэлтийн явцад хяналт шинжилгээ хийж үзэхэд тогтоол, шийдвэрийн хэрэгжилт нийт дүнгээрээ 94,8 хувийн биелэлттэй байна. Шийдвэрүүдийн хэрэгжилтийг Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолын дагуу хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлэхэд анхаарч ажиллаж байна.</p>	90%
8.	Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон төсвийн хөрөнгийг үрлэгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, авлига хээл хахуульд холбогдсон, ёс суртахууны доголдол гаргасан, архидан согтуурсан тохиолдолд улс төрийн хариуцлага хүлээнэ. Хариуцлага алдаж албан тушаалаасаа чөлөөлөгдөх асуудал нь улс төрийн намын хаацайллыг эрэлхийлэх шалтгаан болохгүй.	<p>“Хэнтий аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай” Засаг даргын тайланг аймгийн ИТХ-ын гуравдугаар хуралдаанаар хэлэлцээд, “Аймгийн Засаг дарга Ч.Эрдэнэбаатар 2009 онд мөрийн хөтөлбөртөө тусгагдсан асуудлуудыг амжилттай хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэддээ ил тод шуурхай үзүүлж, аймгийн эдийн засгийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, орон нутгийн төсвийг бүрдүүлэх, амьжиргааны түвшингээс доогуур амьдралтай иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөгжүүлэхэд онцгой анхаарч үр дүнд хүрч ажиллаж байгааг тэмдэглээд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2009 оны хэрэгжилтийг “хангалттай сайн” гэж дүгнэж 2009 оны 12 дугаар сарын 20-нд 04 тоот тогтоол гаргасан байна.</p>	100%
9.	Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг жил тутам Засгийн газарт тайлагнана.	Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг гаргаж, Засгийн газрын 2006 оны 160-р тогтоолын дагуу Засгийн газарт тайлагнаж байна.	100%
10.	Батламж нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.	Батламж гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн энэхүү батламжаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна	100%
БАТЛАМЖААР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ /НИЙТ ДҮН хувиар/			98%